

“ЛЭНДМН ББСБ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 дугаар сарын 26-ны өдөр

№ 26/17

Улаанбаатар хот

**Зээлээр эх үүсвэр татан төвлөрүүлэх,
гэрээ байгуулах эрх олгох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.18 дахь заалт, 80 дугаар зүйл, “ЛэндМН ББСБ” ХК (цаашид **“Компани”**) -ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.6.4 дэх заалт, Компанийн Төлөөлөн удирдах зөвлөл (цаашид **“ТУЗ”**)-ийн 2026 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн эчнээ санал хураалтын дүнг тус тус үндэслэн ТУЗ-өөс дараах тогтоолыг гаргав:

ТЭМДЭГЛЭХ НЬ:

- (i) Компанийн зүгээс өөрийн зээлийн бүтээгдэхүүнүүдийн цар хүрээг тэлэх, харилцагчдынхаа өсөн нэмэгдэж буй эрэлт хэрэгцээг хангаж, санхүүгийн зах зээлд санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилгын хүрээнд гадаад, дотоодын хөрөнгө оруулагчид, санхүүгийн байгууллагаас эх үүсвэр татан төвлөрүүлэх үйл ажиллагааг 2023 оноос эхлэн хэрэгжүүлж буйг дурдсугай.
- (ii) Компани нь Helicap Income Opportunities Fund болон бусад боломжит зээлдүүлэгч нар (цаашид **“Зээлдүүлэгч”** гэх)-ын нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулж буй Alternative Investments VCC-аас Компанийн Боломжит авлага болон Банкны дансдыг тэргүүн ээлжинд барьцаалж, үүргийн гүйцэтгэлийг баталгаажуулах нөхцөлтэйгээр нийт 25,000,000 ам.доллар хүртэлх хэмжээний зээлийн санхүүжилт (цаашид **“Нийт санхүүжилт”** гэх)-ийг Синдикат санхүүжилтийн гэрээ (цаашид **“Зээлийн гэрээ”** гэх) байгуулах замаар татан төвлөрүүлэх тохиролцоонд хүрсэн болохыг тэмдэглэсүгэй.
- (iii) ТУЗ нь Зээлийн гэрээ болон энэхүү Тогтоолын 2.1-2.5-р зүйлд заасан бусад баримт бичгүүдийн (цаашид хамтад нь **“Санхүүжилтийн баримт бичгүүд”** гэх) төслийг хүлээн авч, тэдгээрийн нөхцөлүүдтэй танилцсан болохыг дурдсугай.
- (iv) ТУЗ нь тус Тогтоолын (ii) болон (iii)-т дурдсан Санхүүжилтийн баримт бичгүүдийг баталгаажуулж, хэрэгжүүлэх нь гагцхүү Компанийн ашиг сонирхлын төлөө бөгөөд Компанийн хөрөнгө оруулагчдын хувьд үр ашигтай шийдвэр мөн гэж дүгнэж буйг тэмдэглэсүгэй.

ИЙМД, ШИЙДВЭРЛЭХ НЬ:

1. Энэхүү тогтоолын (ii)-т дурдсан Нийт санхүүжилтийн эхний хэсэг болох 9,000,000 ам.доллар (**“Эхний санхүүжилт”**)-ыг авч ашиглахыг Компанид зөвшөөрсүгэй.
2. Нийт санхүүжилтийг авч ашиглахтай холбогдуулан дараах гэрээ, баримт бичгүүд, түүнчлэн энд дурдагдаагүй боловч шаардлагатай бусад бүхий л баримт бичгүүдийг зохих ёсоор үйлдэж, баталгаажуулахыг Компанид зөвшөөрсүгэй. Үүнд:

2.1. Зээлийн гэрээ (Syndicated Secured Facility Agreement);

- 2.2. Компанийн Боломжит авлага болон Банкны дансад тэргүүн ээлжийн барьцааны эрх үүсгэх нөхцөлтэй Барьцааны гэрээ (Pledge Agreement);
- 2.3. Зээлийн гэрээнд заасан бусад Санхүүжилтийн баримт бичгүүд (the Finance Documents);
- 2.4. Компанийн нэрийн өмнөөс үйлдэх мэдэгдэл, тайлан, тайлбар, баталгаа, батламж, маягт, сертификат, гэрчилгээ, болон түүнд гэрээний талуудын тохиролцсон эсхүл шаардсан байдлаар оруулсан өөрчлөлтүүд, түүнчлэн энд дурдагдаагүй боловч Нийт санхүүжилттэй холбоотой үйлдэгдэх аливаа бусад гэрээ болон баримт бичгүүд; болон
- 2.5. Энд дурдсан баримт бичгүүдэд оруулсан аливаа нэмэлт, өөрчлөлт, тэдгээртэй хамааралтайгаар үйлдсэн болон бусад дагалдах баримт бичгүүд,

(дээр дурдсан баримт бичгүүд нь зөвхөн Эхний санхүүжилтэд бус Нийт санхүүжилтэд хамаарах бөгөөд, цаашид хамтад нь **“Санхүүжилтийн баримт бичгүүд”** гэх).

3. ТУЗ нь Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д энэхүү Санхүүжилтийн баримт бичгүүдийн нөхцөлийг тохиролцох, эдгээрийн нөхцөлийг эцэслэх, улмаар зөвшөөрөх, гарын үсэг зурах, баталгаажуулах, мөн гүйцэтгэх, хэрэгжүүлэхэд шаардлагатай бусад арга хэмжээ авч ажиллах бүрэн эрхийг олгож, хэрэв Эхний санхүүжилтийн хэмжээнээс давсан аливаа санхүүжилтийг хүлээн авах бол тус Тогтоолын 6 дугаар зүйлд дурдсаны дагуу ТУЗ-өөс урьдчилсан зөвшөөрөл авахаар тогтоосугай.
4. Зээлийн гэрээ болон түүний нөхцөлийг энэхүү Тогтоолын Хавсралт 1-т заасан хувилбараар баталсугай.
5. Санхүүжилтийн баримт бичгүүд, түүнтэй холбоотой авч хэрэгжүүлэх аливаа үйл ажиллагаа, Эхний санхүүжилтийн ашиглалт болон түүний явцын талаарх мэдээллийг Компанийн ТУЗ-д тухай бүр тайлагнахыг Компанийн Гүйцэтгэх захирал (Ц.Ууганбаяр)-д үүрэг болгосугай.
6. Нийт санхүүжилтийн хүрээнд Эхний санхүүжилтийн дүнгээс давсан аливаа санхүүжилт авах буюу санхүүжилтийн эрхээ хэрэгжүүлэх бол тухай бүр ТУЗ-өөс урьдчилан зөвшөөрөл авахыг дурдсугай.
7. Энэхүү Тогтоолд том үсгээр тэмдэглэсэн нэр томьёог тусгайлан өөрөөр тайлбарлаагүй бол Зээлийн гэрээнд тодорхойлсонтой ижил утгаар ойлгоно.
8. Энэхүү Тогтоолыг Монгол болон Англи хэл дээр үйлдэх бөгөөд эдгээр нь хоорондоо зөрчилдсөн тохиолдолд Англи хэл дээрх хувийг баримтална.

